



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/75

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын 2017 оны А/96 дугаар тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Амгалан дулааны станц ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн шуурхай зөвлөлгөөн зохион байгуулах журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан Өдөр тутмын техникийн шуурхай зөвлөлгөөнд оролцох албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн баталсугай. Үүнд:

1.1 Өдөр тутмын техникийн шуурхай зөвлөлгөөнд оролцох албан тушаалтан:

1. Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер
2. Зуухан цехийн дарга
3. Түлш дамжуулахын цехийн дарга
4. Нэгдсэн цехийн дарга
5. Аж ахуй хангамжийн албаны дарга
6. Авто хүнд машин механизмын хэсгийн инженер
7. Ээлжийн инженер
8. Горимын хяналт, тооцооны инженер
9. Гэрээ, борлуулалтын инженер
10. Захиргаа удирдлагын хэлтсийн төлөөлөл
11. ХАБЭААжилтан
12. Техник хяналтын инженер
13. ГАБЭХИнженер
14. Шаардлагатай үед Гүйцэтгэх захирал оролцож үүрэг даалгавар өгч биелэлттэй танилцах эрхтэй.

2. Техникийн шуурхай зөвлөлгөөн зохион байгуулах журмын 2.2 дахь хэсэгт заасан Өргөтгөсөн техникийн шуурхай зөвлөлгөөнд оролцох албан тушаалтнуудын жагсаалтыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

2.1 Өргөтгөсөн техникийн шуурхай зөвлөлгөөнд оролцох албан тушаалтан:

1. Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер
2. Санхүү эрхэлсэн дэд захирал
3. Аж ахуй эрхэлсэн дэд захирал

4. Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
5. Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч
6. Зуухан цехийн дарга
7. Түлш дамжуулахын цехийн дарга
8. Нэгдсэн цехийн дарга
9. Хяналтын хэсгийн дарга
10. Аж ахуй хангамжийн албаны дарга
11. Авто хүнд машин механизмын хэсгийн инженер
12. Эмч
13. Горимын хяналт, тооцооны инженер
14. Гэрээ, борлуулалтын инженер
15. Шаардлагатай үед Гүйцэтгэх захирал оролцож үүрэг даалгавар өгч биелэлттэй танилцах эрхтэй.

3. Гүйцэтгэх захирлын 2017 оны А/96 дугаар тушаалын хавсралтад заагдсан “Техникийн шуурхай зөвлөлгөөн зохион байгуулах журам”-ын 2.1, 2.2 дахь хэсгийг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг холбогдох албан тушаалтнуудад танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн Г.Саруулд үүрэг болгосугай.

5. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ган-очирт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ш.БАЯНМӨНХ